

ӨМНӨХ ҮГ

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, Хүн Амын Сургалт Судалгааны Төвтэй хамтран НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 13 дахь дугаарыг бэлтгэж, эрхэм уншигч та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн “Судалгаа” хэсгээс Боловсролын салбарт ажиллагсдын жендэрийн сегрегаци ба гэрийн хөдөлмөрийн нөлөө; Аймгуудын хүн амын нас баралтын бодит түвшинг үнэлэх нь; Улаанбаатар хотын оёдлын үйлдвэрүүдэд хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн хөдөлмөрийн нөхцөл, байдлын судалгаа зэрэг жендэр, хүн амын эрүүл мэнд, нийгмийн асуудлыг хөндсөн сонирхолтой судалгааны ажлуудтай танилцах болно. Түүнчлэн Био-хүн амзүйн чиглэлээр хийгдсэн Монголын хүүхдийн бие бялдар, дотор эрхтний өсөлт хөгжлийн судалгааны үр дүнтэй танилцаарай.

Түүнчлэн, “Үзэл бодол” хэсгээс та бүхэн Маркетингийн судалгааг хийхдээ ёс суртанхуунтай хандацгаая гэсэн сэдэвт судлаачийн санал, бодлыг уншиж өөрийн эргэцүүллийг хийх боломжтой.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт нийтлэгдэж буй судалгаа, шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар уншигч та мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлж, манай дараагийн дугаарт өгүүлэл, шүүмж, хэлэлцүүлэг илгээнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Эцэст нь, Монгол улсын хүн ам, хөгжлийн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюун ухаан, мэдлэг чадвараа зориулж буй нийт эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн, оюутан, залуучууд та бүхэндээ болон сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлж байгаа НҮБ-ын Хүн Амын Сангийн Суурин Төлөөлөгчийн Газарт сэтгүүлийн редакцийн нэрийн өмнөөс гүн талархлаа илэрхийлье.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ